

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/104/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: @audit.gov.mn Баян ташаагийн эх аудит ХХК-ийн Аудитор: Б.Хандсүрэн Утас: 99087198 Цахим хаяг: bte.audit@yahoo.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БНА-2024/98/НА-СТА-ТШЗ

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	2
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	4
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Улсын төсөв	6
2.5.2 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан – Орон нутгийн төсөв	Error!
Bookmark not defined.	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	9
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.5.1 Төсвийн төлөвлөлт	10
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ Error! Bookmark not defined.	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/71

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын нормативын хэмжээг шинэчлэн тогтоосон байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Чиглэл батлах тухай” 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу багш, байгууллагын гүйцэтгэлийг үнэлсэн үнэлгээгээр 30,063,9 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Мөн 218,565.2 мянган төгрөгийн барилга, байгууламж, 428,576.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 35,520.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил нэмэгджээ.

5020270

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 242,290.1 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 240, 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төсвийн захирагч 8 зорилтын хүрээнд 106 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 96 арга хэмжээг бүрэн, 10 арга хэмжээг 70 хувь буюу нийт дүнгээр 90.1 хувиар биелүүлж биелэлтийг хүргүүлсэн дээд байгууллагаас 85 хувиар дүгнэгдсэн.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	189,304,856.13	205,532,599.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	85,036,993.12	118,579,225.93
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	85,036,993.12	118,579,225.93
3121	Төгрөг	85,036,993.12	118,579,225.93
31211	Төрийн сангийн харилцах	85,036,993.12	118,579,225.93
33	АВЛАГА	1,660,000.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,660,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	102,607,863.01	86,953,374.01
351	Түүхий эд материал	17,443,454.40	22,613,411.40
35110	Тусгай зориулалттай материал	17,443,454.40	22,613,411.40
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	25,000,000.00	00.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	25,100.00	237,700.00
354	Хангамжийн материал	60,139,308.61	64,102,262.61
35410	Бичиг хэргийн материал	1,018,260.00	1,229,000.00
35420	Аж ахуйн материал	42,931,569.61	59,997,434.61
35450	Барилгын засварын материал	10,000,000.00	00.00
35460	Хүнсний материал	81,530.00	201,430.00
35470	Бусад хангамжийн материал	6,107,949.00	2,674,398.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,295,361,718.04	1,508,126,226.11
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,295,361,718.04	1,508,126,226.11
392	Биет хөрөнгө	1,268,985,718.04	1,481,750,226.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,183,417,394.47	1,401,982,608.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	-116,239,922.98	-149,997,438.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	261,081,873.07	303,658,653.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	-161,282,452.19	-201,203,211.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	150,425,515.11	185,945,515.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	-95,553,353.39	-104,114,348.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,735,903.98	38,735,903.98
39215	Хуримтлагдсан элэгдэл	-15,413,877.24	-17,072,092.32
39217	Ном	23,814,637.21	23,814,637.21
393	Биет бус хөрөнгө	26,376,000.00	26,376,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-450,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	26,376,000.00	26,376,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,484,666,574.17	1,713,658,826.05
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	377,000.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	377,000.00	00.00
413	Өглөг	377,000.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	377,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,484,289,574.17	1,713,658,826.05
51	Засгийн газрын хувь оролцоо	1,484,289,574.17	1,713,658,826.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	319,214,873.32	319,214,873.32

**Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

51101	Өмч: - төрийн	319,214,873.32	319,214,873.32
512	Хуримтлагдсан үр дүн	264,238,090.13	493,607,342.01
51210	Өмнөх үеийн үр дүн	264,238,090.13	264,238,090.13
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	900,836,610.72	900,836,610.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,484,666,574.17</u>	<u>1,713,658,826.05</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,236,186,893.00	1,677,772,763.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,381,093.00	271,384,463.00
120	Нийтлэг татварын бус орлого	47,381,093.00	271,384,463.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,073,600.00	4,653,421.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,073,600.00	4,335,121.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,188,805,800.00	1,406,388,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,039,466,500.00	1,281,756,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,039,466,500.00	1,281,756,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	149,339,300.00	124,631,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	149,339,300.00	124,631,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,161,677,953.91	1,413,403,511.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,161,677,953.91	1,413,403,511.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,075,155,500.91	1,318,398,264.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	731,776,312.27	879,319,074.76
210101	Үндсэн цалин	516,174,046.33	602,667,187.56
210102	Нэмэгдэл	162,081,472.94	231,833,780.20
210104	Урамшуулал	17,515,967.00	44,818,107.00
210105	Гэрээт ажлын хөлс	36,004,826.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,502,482.81	110,811,570.91
210201	Тэтгэврийн даатгал	63,431,882.20	74,951,440.85
210202	Тэтгэмжийн даатгал	4,060,889.42	8,997,379.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,761,020.95	7,148,739.84
210204	Ажилгүйдлийн даатгал	931,698.66	1,719,329.19
210205	Эрүүл мэндийн даатгал	9,316,991.58	17,994,682.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,803,130.00	120,174,284.37
210301	Гэрэл, цахилгаан	4,767,530.00	6,431,268.37
210302	Түлш, халаалт	96,485,600.00	113,743,016.00
210303	Цэвэр, бохир ус	550,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,418,135.00	3,695,540.00
210401	Бичиг хэрэг	13,614,240.00	3,695,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,750,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,811,515.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	2,242,380.00	00.00
2105	Нормативт зардал	52,006,120.00	74,499,650.00
210502	Хоол, хүнс	47,409,375.00	74,499,650.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,596,745.00	00.00

**Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,166,000.00	2,254,000.00
210604	Урсгал засвар	2,166,000.00	2,254,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,137,100.00	5,323,633.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,220,100.00	858,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,417,000.00	4,465,333.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,346,220.83	122,320,510.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,740,000.00	38,084,610.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,606,220.83	83,897,485.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,522,453.00	95,005,246.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,916,500.00	92,547,831.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,396,500.00	62,018,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,520,000.00	30,258,758.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,605,953.00	2,457,415.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,605,953.00	2,457,415.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	74,508,939.09	264,369,251.88
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	74,508,939.09	229,369,251.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,192,379,400.00	1,411,041,721.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,573,600.00	4,653,421.00	
120	Нийтлэг татварын бус орлого	3,573,600.00	4,653,421.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,573,600.00	4,653,421.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,573,600.00	4,335,121.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,188,805,800.00	1,406,388,300.00	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,039,466,500.00	1,281,756,600.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,039,466,500.00	1,281,756,600.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	149,339,300.00	124,631,700.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	149,339,300.00	124,631,700.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,086,737,766.88	1,328,522,708.19	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,086,737,766.88	1,328,522,708.19	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,011,616,983.88	1,232,381,423.56	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	728,018,558.33	875,074,756.76	
210101	Үндсэн цалин	517,898,301.50	598,422,869.56	
210102	Нэмэгдэл	156,599,463.83	231,833,780.20	

**Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210104	Урамшуулал	17,515,967.00	44,818,107.00
210105	Гэрээт ажлын хөлс	36,004,826.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,502,483.55	110,811,570.91
210201	Тэтгэврийн даатгал	63,431,882.94	74,951,440.85
210202	Тэтгэмжийн даатгал	4,060,889.42	8,997,379.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,761,020.95	7,148,739.84
210204	Ажилгүйдлийн даатгал	931,698.66	1,719,329.19
210205	Эрүүл мэндийн даатгал	9,316,991.58	17,994,682.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,803,130.00	120,174,284.37
210301	Гэрэл, цахилгаан	4,767,530.00	6,431,268.37
210302	Түлш, халаалт	96,485,600.00	113,743,016.00
210303	Цэвэр, бохир ус	550,000.00	00.00
2105	Нормативт зардал	58,720,130.00	72,977,430.00
210502	Хоол, хүнс	58,720,130.00	72,977,430.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,348,000.00	5,207,633.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,941,500.00	318,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,406,500.00	4,889,333.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,224,682.00	46,135,748.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,610,882.00	34,574,548.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,613,800.00	11,561,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,120,783.00	96,141,284.63
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,514,830.00	93,683,869.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,994,830.00	63,153,420.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,520,000.00	30,063,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,605,953.00	2,457,415.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,605,953.00	2,457,415.63
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	105,641,633.12	82,519,012.81
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,604,640.00	48,976,780.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,604,640.00	48,976,780.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,604,640.00	48,976,780.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,604,640.00	48,976,780.00

**Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-20,604,640.00	-48,976,780.00	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	85,036,993.12	33,542,232.81	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	85,036,993.12	118,579,225.93	

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2011оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,873.32	900,836,610.72	264,238,090.13	1,484,289,574.17
D01	2022оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,873.32	900,836,610.72	264,238,090.13	1,484,289,574.17
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	319,214,873.32	900,836,610.72	264,238,090.13	1,484,289,574.17
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	229,369,251.88	229,369,251.88
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,214,873.32	900,836,610.72	493,607,342.01	1,713,658,826.05

2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-85,036,993.12	(85,036,993.12)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,497,253,600.00	1,374,528,191.19	122,725,408.81	91.8
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,497,253,600.00	1,374,528,191.19	122,725,408.81	91.8
210	Бараа, үйлчилгээний зардал	1,390,673,600.00	1,278,853,455.56	111,820,144.44	92.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	961,631,400.00	875,074,756.76	86,556,643.24	91.0
210101	Үндсэн цалин	647,935,600.00	598,422,869.56	49,512,730.44	92.4
210102	Нэмэгдэл	266,337,300.00	231,833,780.20	34,503,519.80	87.0
210104	Урамшуулал	47,358,500.00	44,818,107.00	2,540,393.00	94.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,203,600.00	110,811,570.91	9,392,029.09	92.2
210201	Тэтгэврийн даатгал	1,738,300.00	74,951,440.85	6,786,859.15	91.7
210202	Тэтгэмжийн даатгал	9,616,300.00	8,997,379.03	618,920.97	93.6
210203	ҮОМШӨ ний даатгал	7,693,000.00	7,148,739.84	544,260.16	92.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1,923,300.00	1,719,329.19	203,970.81	89.4
210205	Эрүүл мэндийн даатгал	19,232,700.00	17,994,682.00	1,238,018.00	93.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,631,700.00	120,174,284.37	2,457,415.63	8.0

**Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210301	Гэрэл цахилгаан	5,177,900.00	6,431,268.37	(1,253,368.37)	124.2
210302	Түлш, халаалт	116,133,800.00	113,743,016.00	2,390,784.00	97.9
210303	Цэвэр, бохир ус	1,320,000.00	-	1,320,000.00	-
2105	Нормативт зардал	76,452,100.00	72,977,430.00	3,474,670.00	95.5
210502	Хоол, хүнс	76,452,100.00	72,977,430.00	3,474,670.00	95.5
2106	Эд хогшил худалдан авах	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	11,034,500.00	5,207,633.52	5,826,866.48	47.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажилүйлчилгээний төлбөр, хураамж	3,325,800.00	318,300.00	3,007,500.00	9.6
210806	Мэдээллийн технологийн зардал	7,708,700.00	4,889,333.52	2,819,366.48	63.4
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	95,720,300.00	92,607,780.00	4,112,520.00	95.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,157,300.00	81,046,580.00	4,110,720.00	95.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,580,000.00	93,217,320.00	13,362,680.00	87.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	76,516,100.00	63,153,420.00	13,362,680.00	82.5
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	30,063,900.00	30,063,900.00	-	100.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,457,415.63	(2,457,415.63)	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,457,415.63	(2,457,415.63)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,412,218,800.00	1,408,070,424.00	4,148,376.00	99.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,281,756,600.00	1,281,756,600.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,281,756,600.00	1,281,756,600.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	124,631,700.00	124,631,700.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	124,631,700.00	124,631,700.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,830,500.00	1,682,124.00	4,148,376.00	28.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,325,800.00	318,300.00	3,007,500.00	9.6
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,504,700.00	1,363,824.00	1,140,876.00	54.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	85,036,993.12	(85,036,993.12)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	118,579,225.93	(118,579,225.93)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	49.00	49.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	36.00	36.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд суралцагчдын мэдлэг чадвар, багшийн хөгжлийг дэмжих, хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэн ажиллах чиг үүрэгтэй байгууллага юм.

Тус байгууллага нь дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- Суралцагсдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь боловсрол эзэмшүүлэх, тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс шинээр мөрдөгдөж эхэлсэн.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

**Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 228,992.3 мянган төгрөгөөр буюу 15.4 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт Б	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	85,036.9	118,579.2	33,542.2
Авлага	1,660.0	0	-1,660.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	102,607.8	86,953.3	-15,655.4
Үндсэн хөрөнгө	1,295,361.7	1,508,126.2	212,764.5
Нийт хөрөнгө	1,484,666.5	1,713,658.8	228,992.3
Өр төлбөр	377.0	0.0	-377.0
Засгийн газрын хувь оролцоо	319,214.9	319,214.9	0,00
Хуримтлагдсан үр дүн	264,238.0	493,607.3	229,369.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	900,836.6	900,836.6	0,00
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,484,666.5	1,713,658.8	228,992.3

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 118,579.2 мянган төгрөг болж 33,542.2 мянган төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээр санхүүжсэнтэй холбоотой байна.

Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Авлага данс үлдэгдэлгүй 1,660.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны ажилчдаас авлага 1,660.0 мянган төгрөг төлөгдсөнөөс нөлөөлжээ.

Бараа материал дансны үлдэгдэл 86,953.3 мянган төгрөг болж 15,655.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн худалдан авалтаар 172,183.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 19,045.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материал үнэ төлбөргүй авч 206,884.0 мянган төгрөгийн зарцуулалт хийснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,508,126.6 мянган төгрөг болж, 212,764.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 218,565.2 мянган төгрөгийн барилга, байгууламж, 42,576.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 35,520.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил нэмэгдсэн, 83,897.4 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой байна.

Өглөг данс үлдэгдэлгүй мөн өмнөх оны ажилчидад өгөх өглөгийн 377.0 мянган төгрөгийг барагдуулснаас нөлөөлжээ.

Хуримтлагдсан үр дүн данс 229,369.3 мянган төгөөр нэмэгдсэн нь тайлант онд 229,369.3 мянган төгрөгийн үр дүнтэй ажилласан нь нөлөөлжээ.

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 242,290.10 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, түлш халаалтын зардал нэмэгдсэнтэй холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,122,355.8 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийг 120,650.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 159,400.8 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 3,981.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ. Төсвийн төсөл нь 2023 оны батлагдсан төсвөөс бага байгаа нь төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэн, мөн цахилгааны төлбөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Дээрх баталсан төсвөөс санхүүжилтийг бүрэн олгож, төсвийн гүйцэтгэлээр тайлант хугацаанд 2,457.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн нь цэвэр бохир ус, түлш халаалтын зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 8 зорилт 106 арга хэмжээнд 1,281,756.6 мянган төгрөг улсын төсвөөс, 124,631.7 мянган төгрөг орон нутгийн төсвөөс, урьд оны үлдэгдлээс 85,036.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 3,325.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагаанаас 2,504.7 төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,281,756.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 318.3 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 1,363.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 124,631.7 мянган төгрөг нийт 1,408,070.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,374,528.2 мянган төгрөг зарцуулж, 48,976.7 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авч 2,457.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлж 118,579.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд үйл ажиллагаанаас олох орлогыг 4,418.4 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,374,528.2 мянган төгрөг буюу 91.4 хувьтай байгаа нь зардлыг хэмнэн дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71601	Ерөнхий Боловсролын сургалт	1,412,218.80	1,374,528.20	37,690.60	97.33
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,185,435.20	1,168,041.90	17,393.30	98.53
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	120,203.60	110,811.60	9,392.00	92.19
83112	Хөтөлбөр төслийн дотоод урсгал	106,580.00	95,674.70	10,905.30	89.77

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12

дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хооронд Баян ташаагийн эх аудит ХХК-ийн аудитор Б.Хандсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Хоролсүрэн, аудитын менежер М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 1,497,343.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,973.5 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,481.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шалгагдагч байгууллага нь нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхгүй арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд 2,457.4 мянган төгрөгийн тогтмол зардлын, нийт 118,579.2 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

**Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, тушаал шийдвэрийг бүрэн мэдээлж, таван саяас дээш 198,473,7 мянган төгрөгийн зарлагын 18 гүйлгээ, 1,334,158,8 мянган төгрөгийн орлогын 42 гүйлгээг бүрэн мэдээлсэн ба хуулийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд нийт 1,374,666,6 мянган төгрөгийн 203 мэдээллийг хугацаанд нь бүрэн 100% байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон 398.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,306.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 450.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	398.8	1	398.8	100.0
Албан шаардлага	3	1,306,7	3	1,306,7	100.0
Зөвлөмж	2	450.0	2	450.0	100.0
Нийт дүн	6	2,155.5	6	2,155.5	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Баянговь сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тус сургууль нь үйл ажиллагааныхаа чиглэлийн дауу байгууллагын хуулийн хүрээнд болон санхүүгийн зарчмын хувьд хууль, дүрэм, журмыг зөрчөөгүй 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг болон материаллаг бус алдаа, зөрчил илэрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгөх санал хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.
